

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 06 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ
12. БНХАУ-ын нүүрсний зах зээл



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.06

ДНБ-ий өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)

2.4 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 6 дугаар сар)

5,206 сая \$

Инфляц

(2025 оны 6 дугаар сар)

8.2 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 6 дугаар сар)

-758 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 6 дугаар сар)

6,581 сая \$

Импорт

(2025 оны 6 дугаар сар)

5,527 сая \$

ГШХО

(2025 оны 1 дүгээр улирал)

666 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 5 дугаар сар)

17.2 хувь

Ажилчдын тоо

(2025 оны 1 дүгээр улирал)

1.38 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний орлогц оны түвшин 62 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)

8.4 хувь

*ХҮИ 2015=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 1 дүгээр улирал)

109.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт


(2025 оны 1 дүгээр улирал)

5.8 хувь



Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж удааширлаа. Үйлчилгээний салбарууд болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт өсөлтийг дэмжсэн бол барилга, худалдаа, тээвэр, цэвэр татвар зэрэг салбарууд агшиж өсөлтийг сааруулав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



- Бодит ДНБ 2025 оны эхний улиралд **2.4 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар тэлж, өсөлтийн 1.0 нэгж хувийг, уул уурхайн салбар 0.8 хувиар тэлж, өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 3.9 хувиар өсөж өсөлтийн 0.4 нэгж хувийг,
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 2.2 хувиар өсөж, өсөлтийн 1.2 хувийг бүрдүүлэв.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 2.3 хувиар агшиж, өсөлтийг 0.4 нэгж хувиар бууруулав.


ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(салбараар)

	2024.1	2025.1
ДНБ	7.9%	2.4%
Хөдөө аж ахуй	-24.8%	35.6%
Уул уурхай	13.3%	0.8%
Боловсруулах	4.9%	3.7%
Цахилгаан, ус	7.7%	5.5%
Барилга	27.7%	-1.1%
Бөөний болон жижиглэн худалдаа	6.0%	-5.8%
Тээвэр	26.9%	-21.6%
Мэдээлэл, холбоо	27.5%	16.5%
Үйлчилгээний бусад	3.4%	7.1%
Цэвэр татвар	13.1%	-2.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт болон үйлчилгээний бусад салбарын өсөлт голлон нөлөөлөв.
- Уул уурхай, боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, өсөлтөд эергээр нөлөөлж байна.
- Харин өмнөх оны суурийн нөлөөгөөр барилгын салбарын бүтээн байгуулалт буурсан бол нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого буурснаар тээврийн салбар агшив.
- Мөн хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурч, худалдааны борлуулалт агшив.

УУЛУУРХАЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



- Уул уурхайн салбар 2025 оны эхний улиралд 0.8 хувиар өслөө.
- Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл 448 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Харин нүүрс, алт, газрын тос, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 оны эхний улиралд буурсан байна.
- Тухайлбал, нүүрс олборлолт 20 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар, төмрийн хүдэр 4 хувиар, газрын тос олборлолт 12 хувиар, алт олборлолт 9 хувиар тус тус буурав.

ХӨДӨӨ АЖ АХУЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




- ХАА-н салбар 2025 оны эхний улиралд 35.6 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байж, том малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 6.2 сая толгой малаар буурснаар сүүлийн 2 жил дараалан агшсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.

1.2 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)2025 оны 1 дүгээр улирал


Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлдэг худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны эхний улиралд 51.2 хувь болж, 2 улирал дараалан буурлаа.

PMI
(50-өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар
(50-өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуй нэгжийн төрлөөр
(50-өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр
(50-өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 1 дүгээр улиралд 51.2 хувь болж, өмнөх улирлаас 7.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар тус тус доогуур гарлаа.
- Сүүлийн 3 жилийн хандлагаар барилгаас бусад салбарын PMI эхний улиралд буурч байсан бол 2025 оны эхний улиралд бүх салбарын PMI буурлаа.
- Барилгын салбарын PMI хамгийн ихээр буюу 17.6 нэгж хувиар унаж, 7 дахь улиралдаа сөрөг хүлээлттэй байна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар эерэг хүлээлтээ хадгалсан бол худалдаа эрхлэгчдийн итгэл сөрөг төлөвт шилжсэн байна.
- 200-гаас дээш ажиллагсадтай том аж ахуй нэгжүүдийн PMI индекс 53.9 хувь болж, өмнөх улирлаас 9.3 нэгж хувийн огцом бууралт үзүүлэв.
- Харин 50-199 ажиллагсадтай дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 5.5 нэгж хувиар буурч 44.6 хувь болсноор эргэн сөрөг төлөвт шилжив.
- Жижиг бизнесүүдийн PMI 6.5 нэгж хувиар буурч, 17 улирлын турш сөрөг хүлээлттэй байна.
- Хөдөлмөр эрхлэлтээс бусад бизнесийн үйл ажиллагааны хүлээлт өмнөх улирлын түвшнээс буурсан хэдий ч нийлүүлэлтийн хүргэлтийн хугацаанаас бусад хүлээлт эерэг хүлээлтийн бүсэд хадгалагдаж байна.
- Үйлдвэрлэлийн хэмжээний PMI өмнөх улиралд 8.8 нэгж хувиар буурсан бол энэ улиралд дахин 10.6 нэгж хувиар уналаа.




Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг өрхийн хэрэглээ болон нийт хөрөнгө оруулалт голлон дэмжлээ.

ДНБ-ий өсөлт
(жилийн өсөлтийн хувь)




- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 9.9 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал, 9.6 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна.
- Харин цэвэр экспорт өсөлтийг 14.9 нэгж хувиар бууруулсны 11.6 нэгж хувийг экспортын бууралт, 3.3 нэгж хувийг импортын өсөлт бүрдүүлсэн байна.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буурсан бол өрхийн хэрэглээ 11.9 хувиар өсөв.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 30.4 хувиар өсөхөд малын зүй бус хорогдол 6.2 сая толгойгоор буурч, биологийн өсөж үрждэг хөрөнгийн нөөц нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 18 хувиар буурсан бол бараа, үйлчилгээний импорт 2.9 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний хагас жилд 2.8 хувиар буурлаа. Уул уурхайн салбарт нүүрс, алт, газрын тос олборлолтын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурсан нь голлон нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний хагаст 18.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэл өссөн ч нүүрс болон газрын тосны үйлдвэрлэл буурснаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 7.5 хувиар буурлаа.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний хагаст 6.7 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, ундаа, катодын зэс болон самнасан ноолуурын хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүн дотор 43 хувийг нь нүүрсний олборлолт эзэлдэг.
 - Нүүрсний олборлолт 2025 оны эхний 6 сард 43.7 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.5 хувиар буурсан байна. 2025 оны 6 дугаар сарын байдлаар нүүрс олборлолт 39.3 хувиар буурсан байна.
- *2024 оны байдлаар


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлех бүтээгдэхүүнээр)

		ӨМНӨХ ОНООС ӨӨРЧЛӨЛТ:
Зэсийн баяжмал	969 мян.тонн	32.0%
Газрын тос	19 сая баррель	-11.1%
Алт	45 тонн	-16.5%
Төмрийн хүдэр	48 сая.тонн	4.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний хагас жилд нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 32 хувиар өсөж 969 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 4.8 сая тоннд хүрч, 4.8 хувиар өссөн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур хэвээр байна.




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар буурсан байна.
- Үнэ өссөн:
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.5 хувиар;
 - Ундаа үйлдвэрлэл 6.9 хувиар;
 - Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.1;
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 54.5 хувиар тус тус өссөн бол
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 20.1 хувиар;
 - Газрын тос олборлолт 1.8 хувиар
 - Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл 1.5 хувиар тус тус буурсан байна.




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний хагас жилд бодит дүнгээр 5.2 хувиар агшлаа. Үүнд цэвэр спирт, мах, архи, сүлжмэл эдлэл, тамхи, шахмал түлш зэрэг бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл буурсан нь нөлөөлжээ.




- Боловсруулсан малын мах 2025 оны эхний хагас жилд 16.0 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурлаа.
- Боловсруулсан нийт махны биет хэмжээ буурсан ч үхэр, адууны махны боловсруулалтын түвшин ахиснаар боловсруулах үйлдвэрлэлийн 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар өслөө.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний хагас жилд 79.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өссөн байна.
- Гурилын үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өслөө.




- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний хагас жилд 287.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өслөө.
- Боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар өсөхөд ус, ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн нөлөөллөө.





- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2025 оны эхний хагас жилд 441 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 56.4 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэл үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар буурсан байна*.

*Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээний бууралт голлон нөлөөлөв.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, металл бэлдэц болон цувимлынх бууралттай байна.




Нүүрс болон газрын тосны олборлолт буурсантай холбоотойгоор төмөр замын ачаа тээвэр эхний хагас жилд 3.8 хувиар буурав. Инфляц өндөр түвшинд хадгалагдсанаар худалдаа, зочид буудал, нийтийн хоолны салбарын бодит орлого буурсан үзүүлэлттэй байна.



ТЭЭВЭР
(тээсэн ачаа, сая тонн)

	2024.06	2025.06	ӨМНӨХ ОНООС
Төмөр зам	21.8	20.9	-3.8%
Уул уурхайн бүт.	15.6	14.6	-6.9%
Агаар*	4.60	4.62	0.6%
	2024.03	2025.03	
Авто зам	17.9	18.2	15%
Уул уурхайн бүт.	17.5	18.2	3.8%

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлаар зарлагддаг.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо




- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
 - Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 5 сард нэрлэсэн дүнгээр 24.6 их наяд төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 7.9 хувиар буурсан байна.
- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 5 сард нэрлэсэн дүнгээр 12 хувь болон 10 хувиар тус тус өссөн байна.
 - Харин инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлогын дүн 4 хувиар, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 6 хувиар буурсан байна.
- Төмөр замаар 2025 оны эхний хагас жилд 20.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 хувиар бага байна. Үүнд, нүүрс болон нефтийн бүтээгдэхүүний тээвэр буурсан нь гол нөлөөлөв.
 - Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 1 хувиар өссөн байна.
 - Авто замаар 2025 оны эхний улиралд 18.2 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар нэмэгдэв.
- 2025 оны эхний хагас жилд Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 328.4 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар өссөн байна.




2025 оны эхний хагас жилийн байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 12.1 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.




- Экспорт 2025 оны 6 дугаар сарын байдлаар 6,581 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурлаа.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.



- Нүүрсний экспортын орлого 2,653 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44 хувиар буурлаа.
- Эсийн баяжмалын экспортын орлого 2,352 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 62 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 412 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 276 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар буурлаа.



- 2025 оны 6 дугаар сарын байдлаар импорт 5,527 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өсөөн байна.
- Нийт импортын 19 хувийг тоног төхөөрөмж, 16 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 12 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Нийт импортын өсөлтийн 87 хувийг суудлын автомашины импортын өсөлт эзэлж байна.




- Нефтийн бүтээгдэхүүний импорт 893 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар буурлаа.
- Тоног төхөөрөмжийн импорт 1,026 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 661 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 45.0 хувиар өслөө.
- Барилгын материалын импорт 672 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өслөө.
- Хүнсний импорт 581 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өслөө.

2.2 УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ

2025.06 сар




2025 оны 6 дугаар сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2025 оны эхний 6 сард 37.9 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буурлаа.



- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2025 оны эхний 6 сард 1,054 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.2 хувиар өслөө.



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2025 оны эхний 6 сард 3,856 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өслөө.




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2025 оны эхний 6 сард 1,786 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар буурлаа.




2025 оны эхний 6 сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ
(сая ам.доллар)




- Малын махны экспорт 2025 оны эхний 6 сард 60 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар буурлаа.

АРЬС ШИР
(сая ам.доллар)




- Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны эхний 6 сард 549 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 70 хувиар буурлаа.

НООЛУУР
(сая ам.доллар)



- Ноолуурын экспорт 2025 оны эхний 6 сард 52 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 72 хувиар буурлаа.

НООС
(сая ам.доллар)



- Ноосны экспорт 2025 оны эхний 6 сард 720 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46 хувиар өслөө.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирждэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)




Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын кокожих нүүрсний 2025 оны 6 дугаар сарын дундаж үнэ 177 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 27 хувиар буурсан байна.

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)




Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 6 дугаар сарын дунджаар 9,991 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 6 дугаар дундаж үнэ 93 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Брент газрын тосны 2025 оны 6 дугаар сарын дундаж үнэ 69 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 11 хувиар өслөө.

4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

2025.06 сар



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 6 сард 2.3 сая тонн нүүрс, 3.0 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 18.2 мянган тонн жоншны баяжмал, 18.1 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.



- 2025 оны 6 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 39.7 сая тонн нүүрс арилжиж, 4.7 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 6 сард 2.3 сая тонн нүүрс борлууллаа.



- 2025 оны 6 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 43 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 45 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 6 дугаар сард хэлцлийн доод үнэ 35 ам.доллар, дээд үнэ 78 ам.долларт хүрэв.




- 2025 оны 6 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 6.1 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 408 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 6 сард 3.0 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.



- Төмрийн хүдэр болон баяжмалын 6 дугаар сарын дуудах дундаж үнэ 63 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 65 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 6 дугаар сард хэлцлийн доод үнэ 60 ам.доллар, дээд үнэ 84 ам.долларт хүрэв.

Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 5 сард 432 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 6 дугаар сарын эцэст өмнөх сараас 12 сая ам.доллараар нэмэгдлээ.



- Төлбөрийн тэнцэл 2025 оны 5 дугаар сарын байдлаар 432 сая ам.долларын алдагдалтай байна.
 - Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 470 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 212 сая ам.доллараар тус тус их байна.
- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 6 дугаар сарын эцэст 5,206 сая ам.доллар болж, өмнөх сараас 12 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 367 сая ам.доллараар тус тус өссөн байна.
- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 6 дугаар сард өдөрт дунджаар 0.3 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,581 төгрөгт хүрлээ.
- Төв банк 2025 оны 6 дугаар сард нийт 425 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
 - Төв банк 2025 оны эхний 6 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 11 хувиар буюу 350 сая ам.доллараар их 3.4 тэрбум ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзэлийн эргэн төлөлтэй холбоотой гаргах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 6 дугаар сард 8.2 хувьд хүрч, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурахад автомашины үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлжээ. Харин өмнөх сартай харьцуулсан бараа, үйлчилгээний үнэ 0.2 хувиар өссөн байна.




- Инфляц 2025 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 8.2 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.4 нэгж хувь (28.9 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 5.8 нэгж хувь буюу 71.1 хувийг эзэлж байна.



- 2025 оны 6 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өсөв.
- Сарын инфляцад хүнсний барааны үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Тухайлбал, үхрийн махны үнэ өмнөх сараас 3 хувиар, хүнсний ногооны үнэ 4.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.




- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 6 дугаар сард суурь инфляц 8.7 хувь гарч, нийт инфляцын 5.3 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 3 сар дараалан буурсан үзүүлэлттэй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт саарч, жилийн инфляцын 2.9 хувийг бүрдүүлээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар буурлаа.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өслөө.




Олон улсад чингэлэг тээврийн үнэ 2,602 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 56 хувиар буурлаа. Хүнсний үнийн индекс 2025 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



- Хүнсний инфляц 2025 оны 6 дугаар сард 5.5 хувь болж, нийт инфляцын 1.6 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц саарахад мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт саарсан нь нөлөөлжээ.
- Хүнсний бус инфляц 9.3 хувь болж, нийт инфляцын 6.6 нэгж хувийг бүрдүүлээ.



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 6 дугаар сард дунджаар 3,578 төгрөг болж, өмнөх сараас 0.1 хувиар суларлаа.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2024 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх сараас 0.4 хувиар өслөө.




- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,602 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 56 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг бууруулж байна.



- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 6 дугаар сард 128 болж, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар, өмнөх сараас 0.5 хувиар тус тус өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр сүүн бүтээгдэхүүн болон мах ургамлын тосны үнэ өссөн бол үр тариа, элсэн чихрийн үнэ буурсан байна.




Төсвийн нийт орлого 2025 оны эхний хагас жилийн байдлаар 14.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.9 их наяд төгрөг буюу 6.1 хувиар буураад байна. Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс буурахад түүхий эдийн үнийн уналт голлон нөлөөлсөн байна.




- Төсвийн нийт орлого 14.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 914.4 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар буурсан байна.
- Дээрх бууралтад ААНОАТ 673 тэрбум төгрөг буюу 21.7 хувиар, нийт АМНАТ-ийн орлого 1,352 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 48.4 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



- Төсвийн зарлага 2025 оны эхний хагас жилийн байдлаар 14.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,062 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ний өдрөөс өмнөх оны инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалингийн хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 3.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 4.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар тус тус өссөн байна.




- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 758 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.0 их наяд төгрөгөөр буурсан байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад нүүрсний үнийн бууралт болон ААНОАТ-ын орлого багассантай холбоотойгоор төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь голлох нөлөө үзүүллээ.




- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны эхний улиралд 34.6 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д эзлэх хувь 37.3 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өсөж, 43.0 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 5 дугаар сард 40.3 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 29.5 хувьд хүрлээ.




- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 6 дугаар сарын эцэст 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 7.2 нэгж хувь, төгрөгийн харилцах -2.5 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 1.9 нэгж хувь, гадаад валютын харилцах -2.5 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 27.5 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 22.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар, өмнөх сараас 1.3 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар тус тус өсөв.



- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны 5 дугаар сарын эцэст 40.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан байна.



- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 5 дугаар сард 17.2 хувь болж, өмнөх сараас 0.02 нэгж хувиар буурсан байна.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 5 дугаар сард 11.9 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа.



Хөдөө аж ахуйн салбар сэргэж хөдөлмөрийн зах зээлийн өсөлтөд эергээр нөлөөлснөөр 2025 оны 1 дүгээр улиралд ажилчдын тоо 1 сая 380 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 62.0 хувьд хүрлээ.




Өрхийн бодит орлогын өсөлт 5.8 хувьд хүрч саарав.






Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 2 дугаар улиралд 270.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.3 хувиар нэмэгдлээ.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО
(мянгад, үйл ажиллагаа эрхлэлтээр)




- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 2 дугаар улиралд 270.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.3 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 17.2 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 8.6 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ
(ААН-ийн тоо, салбараар)




- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 3.4 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 41 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО
(мянгад, ажиллагчдын тоогоор)



- Үйл ажиллагаа явуулж буй 111.7 мянган ААН-ийн 96.7 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 93 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС
(улирал, 2018=100)




- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 1 дүгээр улиралд 104.4-д хүрч өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр сайжирлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 19.6 нэгжээр нэмэгдсэн. Үүнд хэрэглэгчдийн ажлын олдцын үнэлэмж сайжирсан нь нөлөөллөө.
- Харин эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 0.2 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөлийн хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 1.4 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 оны 6 дугаар сард 9.4 хувьд хүрч, өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурлаа.




- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 1.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4 нэгж хувиар буурлаа.



- 2025 оны 5 дугаар сарын байдлаар экспорт 33.0 тэрбум ам.доллар, импорт 24.4 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 8.7 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар буурлаа.
- Импорт 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өслөө.



- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2025 оны 6 дугаар сард 9.4 хувь болж, өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурсан ч өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өссөн байна.
- ОХУ-ын төв банкнаас 6 дугаар сарын 6-ны өдөр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 20 хувьд хүргэх шийдвэр гаргасан.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 6 дугаар сард 47.5 болж, өмнөх сараас 0.5 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 5 дугаар сарын байдлаар 1.8 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар өслөө.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд 5.2 хувиар өслөө.




- БНХАУ-ын эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд 5.2 хувиар өслөө.
- Экспортын өсөлт 2025 оны 6 дугаар сард 5.8 хувьд хүрч сайжирсан бол импорт 2025 оны 6 дугаар сард 1.1 хувиар өссөн байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистикийг нэгтгэгдэн зарлагддаг.




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2025 оны 6 дугаар сард 6.8 хувьд хүрч, эдийн засагчдын хүлээлтээс давлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 2025 оны 6 дугаар сард 4.8 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистикийг нэгтгэгдэн зарлагддаг.



- Хэрэглээний үнийн индекс 2025 оны 6 дугаар сард 0.1 хувь гарч, эерэг боллоо.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 6 дугаар сард -3.6 хувь гарч, үнийн уналт эрчимжлээ.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 6 дугаар сард 49.7 болж, өмнөх сараас сайжирсан ч агшилтыг илэрхийлсэн хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд тэлэлтийг илэрхийлэх 50-аас дээш түвшинд хадгалагдаж байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилтийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц, эрэг зүүнлэлийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ